АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ (ALIN)-НИЙ 19 ДЭХ ЧУУЛГА УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2

ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

4

КАНАД УЛСЫН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ НАР ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА

8

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

*Батласан хууль нь хүн бүрт тэгш үйлчилдэг төр л хамгийн тогтвортой оршдог.*

*Аристотель*

# Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn Хууль зүйн мэдээ сонин 2023.09.29




***Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн "ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС" сэтгүүлийн 2003-2013 онд хэвлэгдсэн дугаарууд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн www.nli.gov.mn цахим хаягт байршлаа. Цаашид цахим номын санд тогтмол шинэ дугаарууд нэмэгдэх тул уншигч та бүхэн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг бүтээлүүдийг тус цахим хуудаснаас унших боломжтой***

## АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ (ALIN)-НИЙ 19 ДЭХ ЧУУЛГА УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА




Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ (ALIN) олон улсын байгууллагын гишүүн орнуудын 19 дэх ээлжит чуулга уулзалтыг Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI), Тайваний Үндэсний Их Сургуулийн Хууль зүйн сургууль хамтран 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Тайваний Тайбэй хотноо амжилттай зохион байгууллаа.

Гишүүн орнуудын төлөөлөгчдийн уулзалт цар тахлын нөхцөл байдлаас үүдэн сүүлийн жилүүдэд цахимаар зохион байгуулагдаж байсан бөгөөд энэ удаагийн хуралд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur) саналын эрхтэйгээр биечлэн оролцлоо. Тус чуулга уулзалтаар Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны тайлан, ирэх онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны чиглэл, шинэ гишүүний элсэлт, 2024 онд зохион байгуулагдах 20 дахь ээлжит хурлыг зохион байгуулах орныг сонгох асуудлыг тус тус хэлэлцэв.



## АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ 19 ДЭХ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ “АЗИ ДАХЬ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН” СЭДВЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Азийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээний 19 дэх олон улсын эрдэм шинжилгээний хурал 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Тайваний Үндэсний Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ 2005 онд үүсгэн байгуулагдсан цагаас гишүүнээр элсэж, жил бүр зохион байгуулагддаг олон улсын эрдэм шинжилгээний хуралд тогтмол оролцож ирсэн.

“Ази дахь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн орчин” сэдвээр зохион байгуулсан энэ удаагийн хуралд Хууль зүйн үндэсний хүрээлэнг төлөөлж тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь “Монгол Улс дахь аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн шинэчлэл” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсан үйл явдлыг илтгэлдээ онцолсон юм.



## ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хуульзүйнүндэснийхүрээлэн нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалт”-ыг 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Сургалтыг ХЗҮХ-ийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Э.Саранцэцэг, НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Бямбадулам нар нээж, үг хэллээ.

Сургалтад Хууль зүйн ухааны Доктор /Ph.D./ дэд проф. А.Алтанзул, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ С.Ганцэцэг, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ Ч.Энхчимэг, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ Р.Мөнхбат, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ Д.Цэцэгдарь нар хичээл зааж, Нийслэлийн 9 дүүргийн 50 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.









# СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

























Эдээр бүтээлүүдийг www.nli.gov.mn сайтаас унших боломжтой боллоо

# ИЛТГЭЛИЙН ЭМХЭТГЭЛ










Хууль зүйн мэдээ
Улсын бүртгэлийн дугаар 1197

Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1, Хууль зүйн үндэсний хүрээлэн.
11-315789
www.nli.gov.mn
Бэлтгэсэн Ц.Энхжин

## ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВИЙН 2023 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ СУДАЛГААНЫ ЖАГСААЛТ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

**V САР** — ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ
*ЭШАА Б.ЭНХ-АМГАЛАН, ЭША О.ЭНХХҮСЛЭН*

**VI САР** — "ЗАХИРГААНЫ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА" ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА
*ЭШАА Б.ТҮМЭНДЭМБЭРЭЛ /PH.D/, ЭША Э.СЭЛЭНГЭ*

**VI САР** — ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ
*ЭШАА Б.ТҮМЭНДЭМБЭРЭЛ /PH.D/, С.МЯГМАРСҮРЭН, Д.БАТНЯМ*

**VI САР** — "ЗЕХ-ИЙН ГОМДОЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА" ТАНДАН СУДАЛГАА
*ЭШАА Б.ТҮМЭНДЭМБЭРЭЛ /PH.D/, ЭША Р.ХАТАНСАЙХАН /LL.M/, Э.СЭЛЭНГЭ*

**VI САР** — ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ
*ЭШАА Б.ЭНХ-АМГАЛАН, ЭША Э.СЭЛЭНГЭ*

**VII САР** — "ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ" ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА
*ЭШАА Б.ЭНХ-АМГАЛАН , ЭША Д.ДЭМИДХАНД, Э.СЭЛЭНГЭ*

## ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВИЙН 2023 ОНЫ IV САРД ГҮЙЦЭТГЭСЭН ЗАХИАЛГАТ СУДАЛГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үр нөлөөний үнэлгээ
2. Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл ба Монгол Улсын Олон улсын гэрээний нийцэл
3. Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаа
4. Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн зардлын тооцоо

*Судлаач:*
*ЭШАА Б.Түмэндэмбэрэл /Ph.D/, Б.Энх-Амгалан, ЭША Х.Буянбат, Р.Хатансайхан, О.Энххүслэн, Д.Дэмидханд, Э.Сэлэнгэ, С.Мягмарсүрэн*

Захиалагч:
*Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар*

## ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВИЙН 2023 ОНЫ III, IV САРД ГҮЙЦЭТГЭСЭН ЗАХИАЛГАТ СУДАЛГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

1. УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ/III сард/



2. УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо/III сард/



3. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо/IV сард/



4. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ/IV сард/



*Судлаач:*
*ЭШАА Б.Тумэндэмбэрэл /Ph.D/,*
*ЭША Р.Хатансайхан, О.Энхчулэн, Э.Сэлэнгэ, Д.Дэмидханд,С.Мягмарсүрэн*

Захиалагч:
*УИХ-ын МАН-ын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн*

## ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВИЙН 2023 ОНЫ I, VII САРД ГҮЙЦЭТГЭСЭН ЦАГ ҮЕИЙН ШИНЖТЭЙ СУДАЛГАА, ЛАВЛАГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

1. **Цахим гадаад паспорт нэвтрүүлсэн гадны улсын туршлага/I сард/**

*Судлаач: ЭШАА Б.Тумэндэмбэрэл /Ph.D/,*
*ЭША Х.Буянбат болон бусад судлаачид*

Захиалагч: *Улсын бүртгэлийн ерөнхий газар*



2. **"Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зарим асуудал" харьцуулсан судалгаа/VII сард/**

*Судлаач: ЭШАА Б.Энх-Амгалан,*
*ЭША Р.Хатансайхан, О.Энхчулэн, Э.Сэлэнгэ*

Захиалагч: *"Эрдэнэс Монгол" ХХК*

3. **"Гүйцэтгэх ажилд тавих УИХ-ын хяналтын тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгаа"**

*Судлаач: Х.Эрдэм-Ундрах /Dr.jur/,*
*Х.Буянбат /LL.M/, О.Энхчулэн /LL.M/*

Захиалагч: *УИХ-ын гишүүн Б.Энхбаяр*



## КАНАД УЛСЫН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ НАР ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА

Канад Улсын Холбооны Шүүхийн Комиссарын алба болон Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн хэрэгжүүлж буй Техникийн Туслалцааны Түншлэлийн төслийн хүрээнд Канад Улсын Холбооны шүүхийн Хэрэг эрхлэх газрын Олон улсын хөтөлбөрийн дарга Олег Шаков, Нью Брансвик мужийн ерөнхий шүүгч Марк Ричард, Алберта мужийн Дээд шүүхийн ерөнхий шүүгч Мари Т.Моро нар 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэн дээр зочиллоо.

Уг уулзалтын үеэр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал (Ph.D) тус хүрээлэнгийн чиг үүрэг, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар танилцуулав.

Түүнчлэн зочид төлөөлөгчид Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл амжилттай сунгагдаж, ирээдүйд хэрэгжүүлэх төслийн цар хүрээ, гол хамтарч хэрэгжүүлэх байгууллагыг судалж байгаагаа илэрхийлсэн бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиг үүргийн ач холбогдлыг онцлон тэмдэглэлээ.

